



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 1/81

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах тухай

Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 8/2/8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шиэвээт 4 дүгээр багийн нутаг “АЖУДС” ХХК-ний баруун талд байрлах 2,0 га газрыг Рашаан, сувилалын газар зориулалтаар, 4 дүгээр багийн нутаг Эрүүл мэндийн төвийн урд талд байрлах 0,04 га газрыг 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууцны зориулалтаар, Уужим 2 дугаар багийн төвийн баруун талд байрлах хуучин атаршсан 20,0 га газрыг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар тус тус газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахимаар 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр явуулсугай.

2. Дуудлага худалдаа явагдах зар мэдээг хуулийн дагуу иргэдэд мэдээлэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Б.Бямбасүрэн) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ